

- 6.6. Холбооны гишүүний хууль бус үйл ажиллагааны улмаас бусдад хохирол учирсан бол, түүнээс үүсэх гэм хорыг Холбоо хариуцахгүй.

ДОЛОО. ХОЛБООНЫ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

- 7.1. Холбоо нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, хувьцаа, бусад үнэт цаас болон холбооны үйл ажиллагааг материаллаг байдлаар хангах бусад эд хөрөнгийг өмчлөлдөө байлгаж болно.
- 7.2. Холбооны эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч нь Холбоо байна.
- 7.3. Холбоо нь дараахь эх үүсвэрээс санхүүжинэ:
- 7.3.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын төсвөөс хувиарласан мөнгөн хөрөнгө;
 - 7.3.2. Гишүүний хураамж;
 - 7.3.3. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 7.3.4. Удирдах зөвлөлийн гишүүний тухайн жилийн санхүүгийн дэмжлэг;
 - 7.3.5. Иргэд, гадаад, дотоодын хуулын этгээд, олон улсын байгууллагын хандив, тусламж;
 - 7.3.6. Зээл, өвийн хөрөнгө, бусад өмчийг хуулын дагуу ашиглах явцад олох хөрөнгө;
 - 7.3.7. Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;
 - 7.3.8. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.
- 7.4. Холбоо нь энэ дүрмийн 7.3-т заасан хөрөнгийг зөвхөн дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаандашиглаж, захиран зарцуулна.
- 7.5. Холбоо нь энэ дүрмийн 7.3-т заасан хөрөнгөөс гишүүдэд хувь хүртээх, гадаад, дотоодын иргэн хуулын этгээдэд хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хориглоно.
- 7.6. Холбооны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга нь холбооны эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглах, түүгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 7.7. Уулын спортыг хөгжүүлэх холбооны үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий санг холбооны дэргэд байгуулж болно. Тус санг байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг удирдах зөвлөл батална.
- 7.8. Холбоо нь зохих хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

НАЙМ. ХОЛБООНЫ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- 8.1. Холбоо нь Монгол Улсад уулын спортыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан тамирчин, дасгалжуулагч, шүүгч, спортын зүтгэлтэн, эрдэмтэн, судлаач, хандивлагч байгууллага, иргэд болон бусад дэмжигчдийг шагнаж урамшуулах зорилго бүхий өөрийн шагналтай байж болно.
- 8.2. Шагнал нь медаль, хүндэт тэмдэг, өргөмжлөл, мөнгөн шагнал зэрэг ямар ч хэлбэрээр байж болно.